



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Сан эго фамили ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/186/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalg@audit.gov.mn">nandinjargalg@audit.gov.mn</a> Санхүүгийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:Altantsetsegya@audit.gov.mn">Altantsetsegya@audit.gov.mn</a> Номч финанс аудит ХХК-ийн захирал: Ц.Эрдэнэбилэг Утас: 88009020 Цахим хаяг: <a href="mailto:nomchfinanceaudit@gmail.com">nomchfinanceaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 115  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН САН ЭГО ФАМИЛИ  
ӨЭМТ-ИЙН ДАРГА Ц.ДУЛАМСҮРЭН  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Сан эго фамили ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Сан эго фамили ӨЭМТ нь тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 683.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, Эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 91.6 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.8 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	53,000.00	4,719,489.26
Дансны авлага		10,952,528.04
Бараа материал		18,824,075.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>53,000.00</b>	<b>34,496,092.30</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө		125,064,544.69
Биет бус хөрөнгө		1,750,000.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>-</b>	<b>126,814,544.69</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>53,000.00</b>	<b>161,310,636.99</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг		1,705,592.00
Бусад өглөг		48,000.00
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>1,753,592.00</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>-</b>	<b>1,753,592.00</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч: - төрийн		
- хувийн	53,000.00	500,000.00
Хуримтлагдсан ашиг		159,057,044.99
Тайлант үеийн ашиг/алдагдал		159,057,044.99
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>53,000.00</b>	<b>159,557,044.99</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>53,000.00</b>	<b>161,310,636.99</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Санхүүжилтын орлого		683,206,507.60
Бусад орлого		78,595,349.08
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>-</b>	<b>761,801,856.68</b>
Ерөнхий ба удирдлагын зардал		602,744,811.69
<b>Үйл ажиллагааны зарлага</b>	<b>-</b>	<b>602,744,811.69</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-</b>	<b>159,057,044.99</b>
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>159,057,044.99</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>159,057,044.99</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>53,000.00</b>	-	-	<b>53,000.00</b>
Тайлант үеийн цэвэр (алдагдал)		-	-	-
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>53,000.00</b>	-	-	<b>53,000.00</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	53,000.00	-	-	53,000.00
<b>Өмчийн өөрчлөлт</b>	447,000.00	-	-	447,000.00
Тайлант үеийн цэвэр (алдагдал)	-	-	159,057,044.99	159,057,044.99
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>500,000.00</b>	-	<b>159,057,044.99</b>	<b>159,557,044.99</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	-	<b>691,616,333.06</b>
Татаас, санхүүжилтийн орлого		672,923,965.10
Бусад мөнгөн орлого		18,692,367.96
<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>	-	<b>594,231,238.80</b>
Ажиллагчдад төлсөн		430,684,453.27
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		35,824,182.11
Бараа материал худалдан авахад төлсөн		75,627,221.83
Бусад мөнгөн зарлага		52,095,381.59
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>97,385,094.26</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>		<b>92,718,605.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		92,718,605.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>92,718,605.00</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	<b>4,666,489.26</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>53,000.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>4,719,489.26</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,570.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 2,570.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг өглөө.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Ажилтанд олгосон шагналаас суутгасан ХХОАТ-ыг тайланд тусгаагүй байна.	1	100.0	1	100.0	-	-	1	100.0	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>100.0</b>	<b>1</b>	<b>100.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>100.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон цалингаас НДШимтгэл суутгаагүй байна.	1	2,115.2	-	-	-	-	-	-	1	2,115.2	-	-
2	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг тайлагнасан байна.	1	455.2	-	-	-	-	-	-	1	455.2	-	-
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>2,570.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2,570.4</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.